

# П. БАДАРЧ “ЕСӨН ЭРДЭНИЙН ОРОН”



# Товч намтар

**1939 ОНД ТӨВ АЙМГИЙН БАЯНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ ТӨРЖЭЭ.**

**ГОЛ УРАН БҮТЭЭЛ: “ЕСӨН ЭРДЭНИЙН ОРОН”, “АЛТАН ЗООС”, “МОРЬД”, “ХЭРЛЭН”, ЗУРГААН МӨНГӨН МИЧИД”, “ШИРХЭГ ЦАГААН СУВД” ЗЭРЭГ ЯРУУ НАЙРГИЙН ТҮҮВЭР ХЭВЛҮҮЛЖЭЭ.**

**ШАГНАЛ: 2005 ОНД АРДЫН УРАН ЗОХИОЛЧ, 2018 ОНД “ЕСӨН ЭРДЭНИЙН ОРОН” ШҮЛГЭЭРЭЭ ТӨРИЙН СОЁРХОЛ ХҮРТЖЭЭ.**



## ЕСӨН ЭРДЭНИЙН ОРОН

Ивээлт нарны нь цацрал **алтан** эрдэнэ  
Элгэн уулсын нь оргил **мөнгөн** эрдэнэ  
Илчийн улаан гал нь **шүрэн** эрдэнэ  
Ээжийн цагаан сүү нь **сүвд** эрдэнэ  
Энгүй өргөн тал нь **оюу** эрдэнэ  
Эрхэс наадах тэнгэр нь **номин** эрдэнэ  
Элбэрлийн цагаан гэр нь тана эрдэнэ  
Энх үүрийн туяа нь **зэс** эрдэнэ  
Эрхэт ардын нь эв ган эрдэнэ  
Эх орон минь есөн эрдэнэ



Эргэх эх дэлхийн уул усанд тэгшхэн  
Илч гэрлийн гайхамшиг **мандсан нар** алтан билээ  
Энгүй өргөн талын минь шимт хөрсөнд төлжиж  
Эрдэнийн түрүү сугсруулсан **амуу тариа** алтан билээ  
Энэ сайхан монголын минь удам залгасан бүл  
Энхрий хос амрагийн **дурсгалын бөгж** алтан билээ  
Энэрэлт төрийн минь далбаанд эгнэгт өнгөлөг гялалзсан  
**Эрдэнийн соёмбо** үсэг элэгдэшгүй алтан билээ  
Авралын гэгээн нар нь алтан  
Ачтай төрийн минь сүлд алтан  
Арвайн түмэн түрүү нь алтан  
Амраг хосынх нь дурсгал ч алтан  
Миний эх орон алтан эрдэнийн билээ



Саваа дүүрэн мэлтэлзэх Онон Хэрлэнгийн **урсгал**  
Сартай шөнөөр очиход минь мөнгөн хээтэй байв  
Саалийнхаа дээжийг өргөж аянд хүүгээ үдсэн  
Санаа цайлган эжийн минь **цацлын халбага** мөнгөн байв  
Сайны ерөөл тогтоож хоёр гардан барьсан  
Сайхан хос залуусын минь **хуримын хундага** мөнгөн байв  
Саатаж алсад суугаад аавдаа очиж золговол  
Санасан эцгийн минь зэхсэн **эмээл** мөнгөн байв  
Эцгийн зэхсэн эмээл нь мөнгөн  
Ээжийн цацлын халбага нь мөнгөн  
Сар наадсан ус нь мөнгөн  
Сархад мэлтэлзсэн хундага нь ч мөнгөн  
Миний эх орон мөнгөн эрдэнийн билээ



Улсынхаа заяаг түшиж хувьсгалч ах нарын минь  
Уухайлан мандуулсан туг шүр адил улаан билээ  
Уламж эртнээс дээдэлсэн монгол хүний голомт  
Угалз дөлт гал нь минь шүр адил улаан билээ  
Удмаас буян төгс өргөө цагаан гэрийн минь  
Унь тооно бүхлээрээ шүр адил туяаран билээ  
Уул усны савд уран биеэ найгуулсан  
Удвал цэцгийн дэлбээ ч шүр адил дөлтөн билээ  
Хурын улаан цэцэг нь шүрэн  
Хувьсгалын улаан туг нь шүрэн  
Хурц улаан гал нь шүрэн  
Хорол улаан тооно нь шүрэн  
Миний эх орон шүр эрдэнийн билээ



Өргөн талын элгэнд чандамланхан буусан  
Өргөө цагаан **гэрүүд** минь танан өнгөөр  
цавцайна  
Өчнөөн үеийг элээсэн хангайн буурал уулсын  
минь  
Өвгөн **цаст оргил** танан өнгөөр цагаарна  
Өлзийт ерөөл бэлгэдэж өнөр буурал эхийн  
Өргөсөн **сүүний дусал** танан өнгөөр цацарна  
Өнөөдрийн сайхан үеийн бат **цагаан харшууд**  
Өвлөж хойчдоо үлдээх тана эрдэнэ байна  
Хайрын цагаан сүү нь танан  
Ханат цагаан гэр нь цагаан  
Хангайн цагаан оргил нь танан  
Харшийн цагаан орд нь ч танан  
Миний эх орон тана эрдэнийн билээ



Үүлгүй шөнийн тэнгэрт сүүн заадас татуулж  
Өвч түгсэн одод сувд адил гялалзана  
Үелээд татсан талын минь энгээр тархан бэлчсэн  
Үржилт хонин сүрэг минь сувдранхан налайна  
Үнэрт тансаг өвсний ширхгийг тоолон буусан  
Үүрийн ариун шүүдэр сувдан далай байна  
Үр буяны тэнгэр саальчин монгол хүүхнүүдийн минь  
Үсний гоёхон даруулга нь сувдан хээтэй байхым  
Хөх тэнгэрийн одод сувд  
Хөдөө талынх нь сүрэг сувд  
Энх үүрийн нь шүүдэр сувд  
Эгэл хүүхнүүдийн гоёл ч сувд  
Миний эх орон сувд эрдэнийн билээ





Эр биеийн хийморь сэргээж үүрийн талд давхивал  
Энгүй тэнгэр зүүнээсээ зэсийн өнгөөр хаяарлаа  
Ээлт сүргээ хурааж үдшийн хотонд ирвэл  
Энтээх үүлсийн хормой зэс эмжээр татлаа  
Эгшигт дуугаа аялаж айргаа аягалан суувал  
Идээ сөгнөсөн хувин нь зэс бүстэй байлаа  
Энхийн их ордны ган нурууг холбож  
Эвийн гагнуур тавьтал зэсийн өнгөөр цацарлаа  
Саалийн хувингийн бүс нь зэс  
Сайн гагнуурын оч нь зэс  
Онгон үүрийн туяа нь зэс  
Оройн үүлсийн хаяа нь зэс  
Миний эх орон зэс эрдэнийн билээ



Ухаан санаа цэлмээх уулсынхаа хярд гарвал  
Ургаа сум шиг гацуур оюу ногоон байв  
Уудам талдаа ирээд дөрөө мултлан буувал  
Урьхан намрын ганга нь оюу ногоон байв  
Уран бидэр татах нуураа хөвөөлөн алхвал  
Усны цээлд замаг нь оюу ногоон байв  
Унаган хүлгээ хантайрч эмээлийн дөрөө авбал  
Угалз ширээлсэн гөлөм нь оюу ногоон байв  
Усны зөөлөн замаг нь оюу  
Угалз ширээлсэн гөлөм нь оюу  
Урьхан намрын ганга нь оюу  
Уулсын сайхан гацуур нь ч оюу  
Миний эх орон оюу эрдэнийн билээ



Хүү миний заяанд эхийн сүү шиг ариухан  
Хүслийн сайхан тэнгэр номин цэнхэр юм  
Хүлэг морин гүйх хаврын налгар өдөр  
Хүрээлсэн талын зэрэглээ номин цэнхэр юм  
Хүйтэн өвлийг халсан дулаан цагийн билэгдэл  
Хүүшид ургасан яргуй номин цэнхэр юм  
Хүний дээд аавдаа, шинийн нэгэнд золгохдоо  
Хүндлэн барьсан баранзад номин цэнхэр юм  
Эрхсийн цэнхэр тэнгэр нь номин  
Илбийн цэнхэр зэрэглээ нь номин  
Эхний цэнхэр цэцэг нь номин  
Энхийн цэнхэр хадаг нь номин  
Миний эх орон номин эрдэнийн билээ



Эрмэг хүлэг морь минь хазаар даран хатирахад  
Эгшиг татах **амгай зуузай нь** ган билээ  
Илч гэрэл өртөөлсөн аварга их алхаа  
Эрчмийн баганад бэхэлсэн зузаан **утас** ган билээ  
Эх сайхан орныхоо дархан хилийн харуул  
Эр цэргийн зэвсэг эмтэршгүй **илд нь** ган билээ  
Эрхэм алдраа бадруулсан өнөр өөдрөг түмэн  
Эрэлхэг монгол ардын **эв нь** ган билээ  
Уран хазаарын амгай нь ган  
Урсгалт гэрлийн утас нь ган  
Эр цэргийн зэвсэг нь ган  
Эрхэт ардын эв нь ган  
Миний эх орон ган эрдэнийн билээ.




Мэргэд цэцэлсэн далай хөлгөн их **судрыг**  
Миний ард түмэн **есөн эрдэнээр** бичдэг билээ.  
Мөнх бусыг дагасан ачит буурлаа хүндэлж  
Миний ард түмэн **есөн эрдэнэ дэвсдэг** билээ.  
Мөхөлгүй эрдэнийн дээж **есөн эрдэм** төгс  
Миний ард түмэн улсаа бадруулж яваа билээ.  
Мөрөөдөл хүслийн дээд эв хамтад хүрч  
Миний ард түмний **есөн хүсэл** бүрдэх билээ.



# Дараах өгөгдлийн дагуу шүлгийн утгыг ярилцаарай.

Монгол ахуйтай холбоотой	Байгалийн юм үзэгдэлтэй холбоотой	Монголчуудын бүтээсэн соёлтой холбоотой	Бусад
<b>Есөн эрдэнэ</b>			


1. Юу юуг тухайн эрдэнийн өнгөтэй гэсэн байна вэ?
2. Тухайн юм бүр нь дээрх ангиллын алинд хамаарах вэ?
3. Уг юмс монголчуудын эрхэмлэж, шүтэж, дээдэлдэг зүйл мөн үү? Юугаар батлах вэ?



# Шүлгийн сэдэв, гол санааг дүгнээрэй.

Монгол ахуйтай холбоотой Гал Сүү Хонин сүрэг Хувин Амгай	Байгалийн юм үзэгдэлтэй холбоотой Нар Тариа Голын урсгал Удвал цэцэг Уулын оргил Шүүдэр Од, тэнгэр, үүл Намаг, ганга, гацуур, тэнгэр, зэрэглээ, яргуй	Монголчуудын бүтээсэн соёлтой холбоотой Дурсгалын Соёмбо Хуримын хундага Цацлын халбага Унь тооно Гэр, орд Үсний даруулга Гөлөм, хадаг, эв, илд	Бусад Мандуулсан туг Гагнуур Утас
<b>Есөн эрдэнэ</b>			

1. Шүлгийн бадаг бүрийн түлхүүр үг, өгүүлбэр дээр тулгуурлан өөрийн үгээр дүгнэлт хийгээрэй.
2. Гол санааг илэрхийлсэн өгүүлбэрийг шүлгээс олж бичээрэй.



## Сөн хүсэл

1. Мөнхийн хүсэл
2. Жаргалын хүсэл
3. Үрийн хүсэл
4. Эрдмийн хүсэл
5. Эрүүлийн хүсэл
6. Энэрлийн хүсэл
7. Эвийн хүсэл
8. Буяны хүсэл
9. Баяны хүсэл

## Монгол эмэгтэй хүний 9 эрдэм

- Өнгөнд цэвэр
- Үйлэнд уран
- Үрдээ энэрэлтэй
- Үргэлж цэмцгэр
- Хандаа түшигтэй
- Хадамдаа элэгтэй
- Найранд дуутай
- Настанд ерөөлтэй
- Нартад буянтай



## Эр хүний 10 эрдэм

1. Нойронд сэргэг
2. Номонд мэргэн
3. Үнэнд баясалтай
4. Үгэнд цэцэн
5. Дайнд баатар
6. Далайд усч
7. Хуулинд шударга
8. Хуримд цовоо
9. Дээдэд зусаргүй
10. Доодод хайртай








Уг судар нь “Дэлхийн баримтат өв”-д Монгол Улсаас бүртгэгдсэн гурав дахь бүтээл боллоо. Үүний өмнө Лу гүний “Алтан товч”, “Монгол Шунхан Данжуур” судрууд уг жагсаалтад бүртгэгдээд байсан. Есөн эрдэнийн Ганжуурын хосгүй үнэт өв нь бурхан Шагжамуни болон түүний шавь нарын туурвисан 1161 зохиолыг 108 боть их цоморлиг зохиол болгон эмхтгэсэн асар том судрын чуулган юм. Бурхан шашны оройн дээд ном болох Ганжуурыг монголчууд 1819 онд болгомол хар цаасан дээр алт, мөнгө, зэс, шүр, сувд, оюу, номин, тана, ган зэрэг есөн эрдэнээр урлажээ.



## Шүлгийн бүтэц, хэл уран сайхныг тайлбарлаарай.

- Айзам хэмжээ үүсгэн, тогтсон ёс журмаар тогтолцоотой хэсэглэн эгнүүлж бичсэнийг шүлэг гэнэ. Тодорхой зохиогчтой байна.
- Мөр, шад, бадаг нь шүлгийг бүтээнэ.



Үгийг төрөл бүрээр холбон найруулж, яруу, тод, хурц дүр, дүрслэлийг бүтээнэ. Уран дүрслэл (зүйрлэл, адилтгал, амьдчилал, хэтрүүлэл ...) болоод яруу хэрэглүүр (толгой сүүл холбох, мөрөн дэх үгийн тоог тэнцүүлэх, яруу асуулт, уран давталт...)-аар илэрнэ.

